



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ГУРВАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 20 өдөр

Дугаар 7/77

Пионер толгой

Согтууруулах ундаа худалдах, түүгээр
үйлчлэхийг түр хугацаанд хориглох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 59 дүгээр зүйлийн 59.1.10 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын хэмжээнд малчдын зөвлөгөөн, спорт урлагийн наадам зохион байгуулахтай холбогдуулан архи, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг 2022 оны 05 дүгээр сарын 20-ний өдрийн 15⁰⁰ цагаас эхлэн 05 дугаар сарын 22-ны 22⁰⁰ цаг хүртэлх хугацаанд түр хориглосугай.

2. Хориглосон хугацаанд архи, согтууруулах ундаа худалдах, болон гар дээрээс худалдан борлуулсан иргэдэд хуулийн дагуу хариуцлага тооцож ажиллахыг сумын цагдаагийн хэсгийн төлөөлөгч Л.Дуламдорж, экологийн байцаагч Д.Азбаяр, цагдаа, цагдаагийн дэд ахлагч А.Бямба-Очир, олон нийтийн цагдаа Б.Сүмбэрзул нарт үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Р.Гантулга)-т даалгасугай.

ДАРГА  Б.ГАНТУЛГА



643101245